

**Хэл зохиолын хүрээлэнгийн эх хэл бичгийн сан хөмрөг
дэх үзэмчин аялгууны хэрэглэгдэхүүн**

Дашдондогийн БОРОЛЗОЙ*

Монгол улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн

Хэл шинжлэлийн салбарын ЭШАА, доктор (Ph.D)

Хураангуй

Судар бичгийн хүрээлэн анх байгуулагдсан 1921 оноос л төр засгийн зүгээс монгол ардын аман зохиол, бичиг соёлын өвийг цуглуулахад анхаарч иржээ. 1950-аад оноос эхлэн бүх аймаг, сум, сангийн аж ахуй, нэгдэл, бригадад нутгийн аялгуу судлах шинжилгээний анги явуулж эхэлсэн байна. Ийнхүү Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн хөдөө орон нутагт аман зохиол, нутгийн аялгуу судлах, сурвалжлан цуглуулах шинжилгээний ангийг жил бүр томилон явуулах болсноор бичмэл болон соронзон бичлэгийн сан хөмрөгийг шинээр үүсгэж, эдгээр хэрэглэгдэхүүнээ судалгааны эргэлтэд оруулах, хадгалах, хамгаалах ажлыг албан ёсоор эхлүүлсэн байдаг билээ. Судар бичгийн хүрээлэнгийн бүдүүвчилсэн хөтөлбөрт эрдэм шинжилгээний төвийн ажлын чиглэлийг тодорхойлохдоо:

а) Хүн зүй, угсаатны зүйн судалгааг монгол овогтны дунд хийх,

б) Монголчуудын амьд хэл яриаг судлах. Үүнд:

1) Монгол овогтны хэл яриа, нутгийн аялгууны зүйлийг цуглуулж харьцуулан судлах,

2) Монгол ардын аман зохиол, уран зохиолын дурсгалыг цуглуулан судлах гэж тодорхойлжээ. (2021: 106)

1961 онд ШУА байгуулагдахад Хэл зохиолын хүрээлэнгийн дэргэд Авиа зүйн лаборатори, аман зохиолын бичмэл материалын сан хөмрөг байгуулагдсан юм. Ийнхүү нутгийн аялгуу судлал, аман зохиолын ховор чухал бичвэр бүрдүүлж халх, дариганга, захчин, дөрвөд, торгууд, хамниган, дархад зэрэг аялгууны тухай олон арван өгүүлэл, толь бичиг, ганц сэдэвт бүтээлүүд хэвлэгдэн гарч “Монгол ард улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас”, “БНМАУ-ын нутгийн аялгуу” бүтээлийн 2 боть хэвлэгджээ. (2004: 28)

Эдүгээ ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөгт үзэмчин түмний Дорнод, Сүхбаатар аймагт Хэл зохиолын хүрээлэнгийн

* © Д.Боролзой

E-mail: borolzoid@mas.ac.mn

эрдэмтэд шинжилгээний ангиар ажилласан эх хэрэглэгдэхүүн болох 20 гаруй хавтас хадгалагдаж байна. Эдгээр дотроос үзэмчин аялгууны судлалтай холбоотой 2 хавтас байх бөгөөд эхнийх нь (Хавтас №16) 1978 оны 7 сарын 26-наас 9 сарын 2-ны хооронд Х.Лувсанбалдан ахлагчтай шинжилгээний ангийн Сүхбаатар аймгийн Асгат, Халзан, Онгон, Наран, Дарьганга суманд нутаглах даригангын аман аялгуу, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан болон Дорнод аймгийн Баянтүмэн сумдад нутагладаг үзэмчний аман аялгуу, Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд нутаглах баргын аман аялгууг судалж нутгийн аялгууны цуглуулсан хэрэглэгдэхүүн бүхий хавтас байгаа бол хоёр дахь хавтас нь (Хавтас №18) 1979 оны 9-р сарын 11-нээс 25 хүртэл 14 хоног Ж.Цолоо ахлагчтай шинжилгээний ангийн Дорнод аймгийн Баянтүмэн, Гурванзагал, Сэргэлэн, Хөлөнбуйр, Дорнод аймгийн Төвөд ажиллаж үзэмчин, барга аялгууны холбогдолтой судалгааны хэрэглэгдэхүүн байна.

Эл өгүүлэлд дээрх хоёр шинжилгээний ангиар нутгийн аялгуу судлаач ахмад эрдэмтдийн цуглуулж ирсэн үзэмчин аялгууны үнэ цэн бүхий судалгааны хэрэглэгдэхүүний талаар өгүүлнэ.

Түлхүүр үг: Монгол хэлний нутгийн аялгууны судалгаа, үзэмчин аялгуу, нутгийн аялгууны хэрэглэгдэхүүн

Удиртгал

“Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршвой” нэрт 17-р зууны үеийн Монголын түүхэн сурвалж бичиг болох Лувсанданзаны зохиосон бүтээлд “...Хөвгүүн Абахайгаа хороолгосны тул Даян хаан цэрэг мордов. Баруун түмэн сонсоод угтан цэрэг мордож, Далан тэргүүнд золголдов. Алагчугуудын Цагаан заарин, үзэмчиний Алдунгэ багш хоёул ер үзэж хаанд айлтгав. Ибарагийн амь нь гал буй. Галд ус хийвээс сайн буюу гэв. Гал түлж мөнгөн аягат усыг галд хийв” (Лувсанданзан, 1990, х 179) гэх мэтээр алагчууд, үзэмчин гэдэг хоёр овог аймгийн нэр гардаг билээ. Ийнхүү үзэмчин гэдэг үг анх Батмөнх даян хааны үед овог отгийн нэрийн шинжтэй гарч ирсэн гэдэг ч судлаач Д.Наранцэцэг “тэгвэл бүр үүнээс өмнө XIII зууны үед үзэмчин угсаатан байсан тухай түүхийн зарим сурвалжид мэдээлж байна” (2011: 19) гээд үүнийгээ Дарма гүүшийн зохиосон “Алтан хүрдэн мянган хэгээст бичиг” болон В.Инжаннашийн “Хөх судар” тэргүүт зохиолуудын баримтаар тодруулан тайлбарлажээ.

Харин үзэмчин хэмээх нэрийн хувьд үзэм хэмээх жимсний нэртэй холбоотой бөгөөд үзэмчин нарын овог дээдэс үзэм ургадаг нутагт анх нутагладаг байснаас ийм нэр үүсжээ гэж үздэг. Өөрөөр хэлбэл “үзэмчин” гэдэг нь “үзэм” гэдэг язгуур дээр “чин” дагавар залгаж бүтсэн үг бололтой. Гэвч зарим нэг эрдэмтэн, тухайлбал академич Б.Ринчен үзэмчин гэдэг үгийн гарлын тухайд “үзмэрч” гэдэг үгнээс үүсэлтэй гэж үзсэн нь байдаг бөгөөд “Монгол бичгийн хэлний зүй”

бүтээлдээ “үзэмчин гэдэг нь үзэж харахын “үзэмэрч” гэдэг үгээс үүсэлтэй. Угтаа үзэмэрчин байснаа үзэмчин болон сунжирчээ” (2007: 22) хэмээжээ. Ийнхүү үзэм жимс ихтэй Үзмийн цагаан ууланд амьдарч байсан хэсэг монголчууд тэрхүү ууланд ургасан зэрлэг үзмийг түүж хэрэглэдэг байсан учир үзэмчин хэмээх угсаатны ондоошил, нэртэй болжээ.

Үзэмчин аялгууг судлах нь монгол хэлний түүхийн нэгээхэн хэсгийг болон монгол хэлийг бусад төрөл хэлтэй харьцуулан судлахад маш чухал ач холбогдолтой юм. Ийнхүү судлахад ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн монгол хэлний нутгийн аялгуу, аман зохиолыг судлах зорилготой ажилласан удаа дараагийн хээрийн шинжилгээний ангийн судалгааны үр дүн үлэмж чухал билээ.

Судалгааны зорилго

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл, бичгийн лабораторид хадгалагдаж байгаа үзэмчин аялгуунд холбогдолтой эх хэрэглэгдэхүүн болох Монгол улсын Дорнод, Сүхбаатар аймагт ажилласан шинжилгээний ангийн тайлан, цуглуулсан эх хэрэглэгдэхүүн, үр дүнгийн талаар өгүүлэхийг зорив.

Судалгааны арга

Энэхүү өгүүлэлд баримт цуглуулах, тооцоолох, задлан шинжлэх, тайлбарлах зэрэг судалгааны арга хэрэглэв.

Судалгааны хэрэглэгдэхүүн

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл, бичгийн лабораторид буй Дорнод, Сүхбаатар аймгаас цуглуулсан үзэмчин аялгууны холбоотой хавтаснууд судалгааны чухал эх хэрэглэгдэхүүн болов.

1


Хавтас №16. Сүхбаатар, Дорнод аймгуудаар явсан Х.Лувсанбалдан ахлагчтай шинжилгээний ангийн тайлан. 1978 оны 11 сарын 10-ны өдөр хуралдсан ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлаар уг шинжилгээний ангийг Сүхбаатар, Дорнод аймагт ажиллуулахаар шийдвэрлэжээ. Уг шинжилгээний анги 1978 оны 7 сарын 26-аас 9 сарын 2 хүртэл Сүхбаатар аймгийн Асгат, Халзан, Онгон, Наран, Дарьганга суманд нутаглах даригангын аман аялгуу, Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Баянтүмэн суманд нутагладаг үзэмчний аман аялгуу, Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд нутаглах баргын аман аялгууг судалж нутгийн аялгууны хэрэглэгдэхүүн цуглуулж иржээ.

Уг хээрийн шинжилгээний ангийн нэгэн гол зорилго нь “Дарьганга, үзэмчин аман аялгууг урьд өмнө судалсан эрдэмтэд эл аялгууны авиан зүйн байгуулал, фонемын систем, авиа зүйн хувирал өөрчлөлтийн талаас нь голлон судалсаар ирэв. Бидний зорилго бол үгсийн сангийн талаар холбогдсон материал цуглуулахаар явсан юм” хэмээн судалгааны тайландаа өгүүлсэн байна. Түүнчлэн “материал цуглуулахдаа зүйл хуваасан толийн маягаар хүний хураангуй, хүний зүйл, хүний бие эрхтний зүйл, зан аашны зүйл гэх мэтээр зүйлчлэн цуглуулж

материалаа эмхэтгэхдээ цагаан толгойн үсгийн дэс дарааллаар болгон нягтал” (хавтас 16)-жээ.

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Баянтүмэн, Сэргэлэн суманд үзэмчин аялгуутнууд нутагладаг. Үзэмчин аялгуутан дотроо баруун үзэмчин, зүүн үзэмчин гэсэн салбар аман аялгуутай. Баруун үзэмчний аман аялгуунд ажигласан авиан зүйн ажиглалт гэвэл шүхэр, шатар, шохой, шүтээн зэрэг үгсийг *jüxer jitar, jütēj* гэж хэлдгийг эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Гэвч ямар авианы нөлөөгөөр хэрхэн ингэж хэлдгийг тодруулсангүй байна. Баримтыг ажиглаж үзвэл шавар, шорой, шугам гэх мэт өдий төдий үгийн ш авиаг хэвээр нь хэлдэг байтал шүхрийг *jüxer*, шатрыг *jitār* гэж хэлж буй нь 2-р үеийн чанга гийгүүлэгчийн нөлөө нэг талаас, нөгөө талаас эртний монгол хэлний *i* авианы тагнайшуулах нөлөөлөл хоёроос шалтгаалж хэлний дундуур хэлэгдэх *j* гийгүүлэгчтэй сэлгэх боломжтой болсноос *š~j* авиа сэлгэжээ гэж дүгнэсэн байна.


Энэхүү хээрийн шинжилгээний ангийн №16 хавтсанд үзэмчин аялгууны судалгааны тайлангаас гадна голчлон буриад, дариганга аялгуутай холбоотой хэрэглэгдэхүүн байна.



Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоол, 1978.11.10

2

Хавтас №18. Дорнод аймгаар явсан Ж.Цолоо даргатай шинжилгээний ангийн тайлан. 1979 оны 10 сарын 1-ний өдөр хуралдсан ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлаар уг шинжилгээний ангийг Дорнод аймагт ажиллуулахаар шийдвэрлэжээ. Уг шинжилгээний анги 1979 оны 9 сарын 11-ээс мөн сарын 25 хүртэл Дорнод аймгийн Баянтүмэн, Гурванзагал, Сэргэлэн, Хөлөнбуйр сум болон Дорнод аймгийн Төвөд ажиллаж үзэмчин, барга аялгууны холбогдолтой хэрэглэгдэхүүн цуглуулжээ.



Ж.Цолоо даргатай шинжилгээний ангийн урьдчилсан тайлан

Эрдэм шинжилгээний албан томилолтын гол зорилго нь үзэмчин, барга аялгууны эгшиг, гийгүүлэгч авианы хэлэгдэх байдлыг (бүтэх аргыг) туршилт

авиа зүйн лабораторийн рентген магнитофоны аргаар судалж, уг хоёр аялгууны зарим авиаг сонсол зүйн шинжээр тодорхойлох байжээ.

Үзэмчин аялгууны а, о, у, ү зэрэг эгшгийн хэлэгдэх байдлыг рентген магнитофоны аргаар судалж Дорнод аймгийн Төвөд суудаг 59 настай эмэгтэй Цэнд овогтой Сэндэмээс зарим, журам, цагаан, чадал, чөдөр, цэцэн, Дорнод аймгийн Сэргэлэн сумын Сундуйн Дамбийхорлоо (эрэгтэй, үзэмчин, 49 настай)-гоос зарим, журам, цагаан, чадал, чөдөр, цэцэн, цээж гэдэг үг, мөн Дорнод аймгийн Сэргэлэн сумын Мандах овогтой Санжаагаас (58 настай, эрэгтэй, зүүн үзэмчин) зарим, журам, цагаан, чадал, чөдөр, цэцэн гэдэг үгийн эхний хамжин шүргэх *dž*, *tš* гийгүүлэгч, эдгээр гийгүүлэгчийн дараа орсон а, о, у, е эгшгийн хэлэгдэх байдлыг рентген аппаратаар буулгаж, магнитофонд бичиж авсан байна.

Үндэсний утга зохиолын хэлний хамжин шүргэх *dž*, *dz*, *tš*, *ts* дөрвөн гийгүүлэгчийг үзэмчин аялгуунд хамжин шүргэх *dž*, *tš*, *š* гэсэн гурван гийгүүлэгчээр дуудах билээ. Үүний хэлэгдэх байдлын тухай, дуудлагын өвөрмөц шинжийг хээрийн шинжилгээний тайланд өгүүлсэн байна. Жишээлбэл, “үндэсний утга зохиолын хэлний холбогдох гийгүүлэгчийг ийнхүү өвөрмөц хэлдэг учир дараах эгшгээ мөн жаахан ондоо дуудлагатай болгосон зүйл ажиглагдаж байна. Ер нь үзэмчин аялгуу нь монгол хэлний бусад аялгуунаас зөвхөн гийгүүлэгчийн хувьд ч биш эгшгийн талаар ялгаатай байна. Энэ ялгааг зөвхөн сонсголоороо ялгах төдийгүй, туршилт авиа зүйн лабораторийн багаж техникээр тодорхойлж болох байна” () гэх мэтээр дэлгэрэнгүй өгүүлжээ.

Харин үзэмчин аялгууны хэл зүйн онцлогийн тухайд “монгол хэлний үзэмчин аялгуу дараах хэдэн шинжээрээ монгол бичгийн хэл болон үндэсний утга зохиолын хэлнээс ялгаатай” гээд дараах дүгнэлтийг хийжээ. Үүнд:

1. Холбохын тийн ялгалын -*luᠢa*, -*lüge* нөхцөл, -*lā*, -*laē*, -*lei* гэсэн хэлбэртэй байна. Эдгээр нөхцөлийг холбогдох үгэнд эгшиг зохицох дарааллын хуулиар цуваанд нь эр, эмээр зохицуулж хэлнэ. Жишээ нь: *bi šam luᠢa aᠢuljamui* - би чамтай уулзана - *bi tšamlā üldžana*, *ci ken irebei* - чи хэнтэй ирэв - *tši xentēi ireb*
2. Харьяалахын тийн ялгалын -*u*, -*ü* нөхцөл -*ā*, -*ē* хэлбэртэй юм. Жишээ нь: *usun-u sabu* - усны сав - *usnā* - *usnē saw*, *kümün-ü ᠢar* - хүний гар - *xünē ᠢar*. Дээрх хоёр шинжээрээ монгол хэлний ойрд аялгуунд ойр юм.
3. Монгол үндэсний утга зохиолын хэлний -руу (луу), -рүү (лүү) нөхцөлтэй адил утга, үүрэгтэй зүг чиг заадаг -*džú*, *džü* нөхцөл бий. Жишээ нь, *baᠢsi surᠢaᠢul yabulā* - багш сургууль руугаа явлаа - *baᠢsi surgüldžú yawlā*. *Ši qoni oši* - чи хонь луугаа очно биз - *tši qonidžü otšino biddē*, *ayil-un kümün ger oruba* - айлын хүн гэр лүүгээ (гэртэй) оров - *aelīn xún gerdžü orob*.
4. Үндэсний утга зохиолын хэлний нөхцөл үйл үгийн -тал, -гэл, -тол, -тул дагаврыг -*tar*, -*ter*, *tor*, *tur* гэж дуудна. Жишээ нь, явтал - *yawtal*, хэлтэл - *xelter*, ортол - *ortor*
5. Үндэсний утга зохиолын хэлний нөхцөл үйл үгийн -хлаар, -хлоор, -хлээр,

-хлөөр дагавартай утга үүргээрээ тохирдог -xlāē, xloē, xlēi дагавар бий. Жишээ нь, Таныг явахаар өгнө - tanīg yawaxlāē ögnö, намар болохоор хийдэг - namar boloxloē xīne

6. Үйлт нэрийн өнгөрөн төгсөөгүй цагийн утга илэрхийлдэг ügüi-гийн оронд -düi буюу -dī дуудна. Жишээ нь, yabuṽa düi - яваагүй, ire ügüi - ирээгүй - ired гэх мэт.

197951025

Батлан,
 Захарал, проф. А. Лувсандэндэв

Берга, үзэмчин аялгуу, аман зохиол
судлах Ж. Цолоогийн томилолтын
зардал

Зардлын нэр	төсөвлөсөн нь	Баталсан нь
1. УБ-Дорнод-УБ	I	I
Насрах онгоцны зардал	I	I
I x I37 x 2	374 тө	374
2. Томилолт	I	I
Ix I3 x I4	I82 тө	182
3. Зочид буудлын хөлс	I	I
I x I5 x I4	210 тө	210
4. Хөдөө унааны зардал:	I	I
а/ Чойбалсан - Гур-	I	I
ванзагал I25 км	I	I
б/ Гурванзагал -	I	I
Сэргэлэн I18 км	I	I
в/ Сэргэлэн - Хөдөн-	I	I
буур - Чойбалсан	I	I
364 км	I	I
г/ Сумдын дотор	I	I
200 км	I	I
бүгд 871 км x I.05	I306 тө 50 цө	1306
Бүгд	2012 тө	1706

Ж.Цолоогийн томилолтын зардал

Дүгнэлт

Монголын хэл шинжлэлийн салбарын олон үеийн судлаачид, ялангуяа нутгийн аялгуу, аман зохиол судлаач эрдэмтдийн монгол хэлний нутгийн аялгуу судлалд оруулсан хувь нэмэр хэмжээлшгүй их билээ. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс 1950-аад оноос эхлэн Монгол улсын бүх аймаг сумдаар ажилласан энэхүү шинжилгээний ангиудын судалгаа шинжилгээний үр дүн, тэдгээрийн тайлангууд эдүгээ ч Эх хэл, бичгийн лабораторид хадгалагдсаар байна. 1961 онд ШУА байгуулагдахад Хэл зохиолын хүрээлэнгийн дэргэд Авиа зүйн лаборатори, аман зохиолын бичмэл материалын сан хөмрөг байгуулагдсан бөгөөд энэ санд нутгийн аялгуу судлал, аман зохиолын ховор чухал бичвэр болоод монгол хэлний олон нутгийн аялгуу болох халх, дариганга, захчин, баяд, дөрвөд, торгууд, хамниган, дархад, өөлд, буриад, үзэмчин зэрэг аялгууны тухай өнөө ч улам үнэ цэнтэй болсоор байгаа олон арван хавтас хадгалагдсаар байгаагийн дотор бидний хувьд хамгийн сонирхолтой нь үзэмчин аялгууг судалсан шинжилгээний ангийн хоёр хавтас бүхий хэрэглэгдэхүүн юм. Уг 1978 оны Х.Лувсанбалдан ахлагчтай шинжилгээний ангийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан болон Дорнод аймгийн Баянтүмэн сумдад нутагладаг үзэмчний аман аялгууг судалсан болон 1979 оны Ж.Цолоо ахлагчтай шинжилгээний ангийн Дорнод аймгийн Баянтүмэн, Гурванзагал, Сэргэлэн, Хөлөнбуйр, Дорнод аймгийн Төвөд ажиллаж цуглуулсан үзэмчин аялгууны холбогдолтой хэрэглэгдэхүүнүүд нь эдүгээ үзэмчин аялгууны тэр цаг үеийн баримтыг авч үлдсэн судалгааны хувьд чухал ач холбогдолтой, маш үнэ цэнтэй зүйл болж байна.

Abstract:

Since the 1950s, local dialect research departments have been operating in all aimags, soums, and farms and collectives in Mongolia. The Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences has been conducting an annual research class on the study, collection, and analysis of folklore and dialects in rural areas. Thus, a new collection of written and magnetic recordings was created, and the work of putting these materials into research circulation, preservation, and protection was officially begun. In 1961, a Phonetic Laboratory and a library of written materials of folklore were established at the Institute of Language and Literature. Currently, the Laboratory of mongolian philology database of the Institute of Language and Literature contains more than 20 folders of original materials used by the Institute of Language and Literature's researchers in Dornod and Sükhbaatar aimags as part of their analysis department. Among these, there are two folders related to the study of üzemchin dialects. The first is the research materials of the research team led by Kh. Luvsanbaldan, which worked in Asgat, Khalzan, Ongon, Naran, and Dariganga soums of Sukhbaatar aimag in 1978. The second folder contains research materials from the research team led by J. Tsoloo, which worked in Bayantimen, Gurvanzagal,

Sergelen, Khölönbuir, and Dornod aimag centers in 1979. This article will discuss the valuable research materials on the üzemchin dialect collected by senior scholars of local dialects in the two aforementioned analysis classes.

Ном зүй

Алимаа, А., Болормаа, Д., Боролзой, Д., Гэрэлмаа, Г., Мөнхбат, Ё., Очирцэнд, М., Пүрэвжав, Э., Сумьяа, Д., Ууганбаатар, Ж., Энхжаргал, С., (2021). *Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн. 100 жил, 100 үйл явдал, 100 зураг, 100 эрдэмтэн.* Улаанбаатар: Соёмбо принтинг хэвлэлийн газар. [Alimaa, A., Bolormaa, D., Borolzoi, D., Gerelmaa, G., Mönkhbat, Yo., Ochirsend, M., Pürevjav, E., Sumiya, D., Uuganbaatar, J., Enkhjargal, *Shinjelekhe ukhaanii akademiin Khel zokhioliin khüreelen. 100 jil, 100 üil yavdal, 100 zurag, 100 erdemten* [The institute of language and literature of the Mongolian academy of sciences. 100 years, 100 events, 100 photos, 100 researcher]. Ulaanbaatar: Soyombo printing. 2021.]

Алимаа, А., Катуу, Б., (2004). *Монгол аман зохиол, нутгийн аялгууны хөмрөгийн бүртгэл.* Улаанбаатар: Соёмбо принтинг хэвлэлийн газар. [Alimaa, A., Katuu, B., *Mongol aman zokhiol, nutgiin ayalguunii khömrögiin бүртгэл* [Registration of written materials kept by collection of mongolian folklore and local dialects]. Ulaanbaatar: Soyombo printing. 2004.]

Наранцэцэг, Д., Долгорсүрэн, Д., (2011). *Үзэмчиний түүх соёлын ойллого.* Улаанбаатар. [Narantsetseg, D., Dolgorsüren, D., *Üzemchinii түүх соёлын ойллого* [History and culture of üzemchin ethnicity]. Ulaanbaatar. 2011.]

Ринчен, Б., (2007). *Монгол бичгийн хэлний зүй.* Улаанбаатар. [Rinchen, B., *Mongol bichgiin khelnii зүй* [Mongolian written grammar]. Ulaanbaatar. 2007]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.